

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ 2022 ОНЫ ЭХНИЙ 10 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2022.11.04

Сүмбэр сум

1.Бүртгэгдсэн гомдол мэдээлэл

Цагдаагийн хэлтэс 2022 оны эхний 10 сард иргэн, хуулийн этгээдээс 1016 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 247 буюу 24.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 769 буюу 75.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Бүртгэгдсэн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан нийт гомдол мэдээлэл 165-аар буюу 14 хувиар буурсан.Үүнээс гэмт хэргийн гомдол мэдээлэл 1-ээр буюу 0.4 хувиар, зөрчлийн гомдол мэдээлэл 166-өөр буюу 17.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт 1016 гомдол мэдээлэл




хүлээн авч шалгаснаас 993 буюу 97.7 хувийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн шинжтэй 247 гомдол мэдээллийн 231 буюу 93.5 хувийг шийдвэрлэснээс хэрэг нээсэн-130, хэрэг нээхээс татгалзаж прокурорт хүргүүлсэн-99, харъяалалын дагуу шилжүүлсэн-2 байна. Гомдол мэдээллийн 34-ийг 5 хоногт, 197-г 6-19 хоногт шийдэж одоо 16 гомдлын үлдэгдэлтэй байна.

Зөрчлийн шинжтэй 769 гомдол мэдээллийн 762 буюу 99 хувийг шийдвэрлэснээс зөрчлийн хэрэг нээсэн-241, хэрэг нээхээс татгалзаж прокурорт хүргүүлсэн-43, хялбаршуулсан журмаар шийдсэн-475, харъяалалын дагуу шилжүүлсэн -3


байна. 762 гомдол мэдээллийг 100 хувь 5 хоногт шийдвэрлэж одоо 7 гомдлын үлдэгдэлтэй байна.

2.Бүртгэгдсэн гэмт хэрэг



Энэ оны эхний 10-р сард нийт 127 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 20-оор буюу 18.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүнд гэмт хэрэг 19 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 2-оор буюу 11.8 хувиар хөнгөн гэмт хэрэг 108 бүртгэгдсэн нь 18-аар буюу 20 хувиар тус тус өссөн. Хэрэг бүртгэлтийн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 106 хэрэг бүртгэгдсэнээс 60 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 56.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн.



Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 5 жилээр тухайн сараар/





Бүртгэгдсэн тодорхой төрлийн гэмт хэрэг /ЭХ-ийн бүлгээр/

№	Гэмт хэргийн төрөл	2021.10 сар	2022.10 сар	Тоо	Хувиар
1.	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11-7/	57	55	-2	-3.5
2.	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /17.1-17.2/	36	60	24	66.7
3.	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /12.1-12.5/	3	4	1	33.3
4.	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг /20.1-20.16/	4	-	-	-
5.	Хүний халдашггүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг /13.1-13.13/	-	-	-	-
6.	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг /15.1-15.6/	2	-	-	-
7.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг	1	1	0	0
8.	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг /25.1-25.6/	-	-	-	-
9.	Эдийн засгийн гэмт хэрэг /18.1-18.18/	-	2	-	-
10.	Хүний амьд явах эрхийн эсрэг ГХ /10.1-10.6/	1	2	1	2 дахин
11.	Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг/27.1-27.11/	3	3	0	0
	Нийт	107	127	20	18.7

Хэргийн өсөлт бууралтыг өнгөөр харуулбал:



Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг




Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Үйлдэгдсэн газар	2021.10 сар	2022.10 сар	Өсөлт, бууралтын хувь
Гэр, орон сууц	59	55	-6.8
Гудамж талбай, олон нийтийн газар	19	16	-15.8
Байгууллага, аж ахуйн нэгж	6	14	2 дахин
Бусад газар	20	39	95
Авто зам	3	3	0


Гэмт хэрэгт холбогдогч

Гэмт хэрэгт 90 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1-ээр буюу 1.1 хувиар өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогсдын нас, нийгмийн байдал




Гэмт хэргийн хохирогч, хохирол



Гэмт хэргийн улмаас 2 хүн нас барсан нь урд оны мөн үеэс 1-ээр буюу 33 хувиар буурсан. 67 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2-оор буюу 2.9 хувиар буурсан.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал



№	Сум	2021.10 сар	2022.10 сар	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянтал сум	8	14	6	75
2	Шивээговь сум	6	14	8	2 дахин
3	Сүмбэр сум	93	99	6	6.5


Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 78 хувийг Сүмбэр суманд, 11 хувийг Шивээговь суманд, 11 хувийг Баянтал суманд үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.

Гурав: Зөрчил

Нийт 19225 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 903-аар буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт 18686 иргэнийг 723282.6 төгрөгөөр торгож 181 иргэнийг баривчлуулж, 352 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасчээ.

Зөрчил үйлдэгдсэн цаг, гараг



Зөрчил үйлдэгдсэн газар

Үйлдэгдсэн газар	Зөрчлийн тоо /2021.10 сар/	Зөрчлийн тоо /2022.10/	Өсөлт бууралтын хувь
Гэр, орон сууц	128	89	-30.4
Гудамж талбай, олон нийтийн газар	68	38	-44
Байгууллага, аж ахуйн нэгж	4	13	3 дахин
Бусад газар	19	8	-57.8
Авто зам	602	580	-366

Зөрчил үйлдэгдсэн онцлогоор:



Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, зөрчилд холбогдсон нийт 424 хүнийг эрүүлжүүлсэн нь урд оны мөн үеэс 207-оор буюу 32.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс эмэгтэй-28, төрийн алба хаагч-1, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч-7, хувиараа хөдөлмөр эрхлэгч-18, төрийн бус байгууллагын ажилтан-0, ажилчин малчин-11, оюутан-0, 18 насанд хүрээгүй хүн-2, ажилгүй-368, бусад-19 хүн байна.

Эрүүлжүүлсэн шалтгаанаар ангилбал: согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гэмт хэрэг, зөрчил холбогдсон-51, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон-130, гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 241 гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2 хүнийг эрүүлжүүлсэн байна.

Дөрөв: Дүгнэлт

1. Гэмт хэрэг урд оны мөн үеэс 18.7 хувиар өссөн нь хулгайлах, залилах, завших зэрэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт өссөнтэй холбоотой байна.

2. Нийт гэмт хэргийн 43.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 47.2 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 9.5 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 14860 буюу 79.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил эзэлж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 18.2 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 8.3 хувиар өсч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.4 хувиар буурч, согтуугаар үйлдэгдсэн зөрчил 1 хувиар өсч хүүхэд оролцсон гэмт хэрэг 4 нэгжээр өссөн. Байгууллага, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил 2 дахин өссөн нь анхаарал татаж байна.

Тав: Санал

- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн сонор сэрэмж, харуул хамгаалалт, теле камерын хүчин чадлыг сайжруулах ажлыг зохион байгуулах
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, зөрчлүүд нь ихэвчлэн ахуйн хүрээнд согтууруулах ундааны зүйл хэрэглэсний улмаас үйлдэгдсэн байх тул согтууруулах ундааны хэрэглээг багасгах чиглэлийн арга хэмжээг аймаг, сумдад зохион байгуулах
- Залилах, мал хулгайлах гэмт хэргийг бууруулах чиглэлээр сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зэрэг болно.

ТАНИЛЦСАН:

ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.БАЯРХҮҮ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Э.БАЯНЖАРГАЛ

